

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛӨӨС
ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023.05.29

Дархан-Уул аймаг

№	Зохион байгуулах ажил	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хувь
Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр			
1	Байгууллага бүр хүүхэд хамгааллын асуудлаар ажиллах Эцэг эхийн зөвлөлийг байгуулж ажиллах	<p>Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тогтоолийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу аймгийн Соёл, урлагийн газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/13 тоот тушаалаар Эцэг эхийн зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.</p> <p>Тус зөвлөл нь хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой мэдээлэл өгөх бөгөөд хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн, ажигласан, таамагласан тохиолдолд гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллага, цагдаагийн байгууллагад холбон зуучлах зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна. Мөн Байгууллагын “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг нийт ажилтан албан хаагч болон иргэд олон нийтэд сурталчилсан.</p>	100%
2	Байгууллагын ажилтнуудын гэр бүлийн дэлгэрэнгүй болон хүүхдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалт, тэдэнд үзүүлэх дэмжлэгийн талаар судалгаа гаргах.	<ul style="list-style-type: none"> - Тус газрын 7 албан хаагчийн 0-18 хүртэлх насны хүүхдийн дэлгэрэнгүй судалгааг гаргасан. Үүнээс цэцэрлэгт 3, ЕБС-д 4 хүүхэд суралцаж байна. - Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу албан хаагчдад хүүхдийнх нь мэндэлсэн өдрөөр цалинтай чөлөө олгож хэвшсэн. - Хүүхдэдээ халамж анхаарал тавих боломжийг олгон бага насны хүүхэдтэй эцэг, эхэд хүүхдээ сургууль, цэцэрлэгт хүргэж өгөх авах, эргүүлд гарах, эцэг эхийн хуралд очих, хүүхдийнхээ соёл, хүмүүжлийн өдөрлөгт оролцох зэрэгт цагийн зохицуулалтыг хийж ажиллаж байна. - Байгууллагын албан хаагчдад хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогийг таньж мэдэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг эзэмшүүлэх сургалтыг 5 дугаар сарын 22-нд зохион байгуулсан. 	100%
3	Хүүхэд хамгааллын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэх.	- 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 167 тоот албан бичгийн дагуу тус газар нь 2023 оны 01 дүгээр улирлын “Хүүхэд хамгааллын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр аймгийн ГБХЗХГ-ын darhan@fcy.gov.mn хаягт хүргүүлсэн.	100%

		- Харьяа соёлын 7 байгууллагад Хүүхэд хамгааллын чиглэлээр төлөвлөгөө гаргаж ажиллах чиглэлийг албан бичгээр хүргүүлсэн.	
Тусламж үйлчилгээний чиглэлээр			
4	Зорилтот бүлгийн хүүхдүүдэд тусламж үзүүлэх.	- Аймгийн Залуучууд театрын дэргэдэх “Шонхоодой” циркийн хүүхдүүдээс ирсэн хүсэлтийг аймгийн Улаан загалмайн хороонд уламжилж хүнсний болон ахуйн хэрэглээний тусламж үзүүлсэн. - “Зүрхэнд Гэрэлтэнэ” МУСК-ны 30 ширхэг билетийг Дарханы Аутизмтай хүүхдийн эцэг эхийн холбоонд бэлэглэсэн. - Мөн 5/1 аяны хүрээнд хуваарьт айлын хүүхдэд сар бүр тусламж хүргэн ажиллаж байна.	90%
Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр			
5	“Нэгдүгээрт хүүхэд” уриан дор: ➢ Дархан-Уул аймгийн соёл, урлагийн байгууллагууд хөшиг нээгдэх бүрд болон аливаа үйл ажиллагаа бүрийн эхэнд “Хүүхдээ сонсоё - Хүлээцтэй байцгаая” уриалгыг хэлж хэвшсэн. Дээрх уриалга дор соёлын байгууллагууд өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан дараах уриаг дэвшүүлэн ажиллаж байна. ➢ Хүүхдийн номын ордон нь “Ирээдүйн уншигчдыг хөтөлнө”	- Соёл, урлагийн үзвэр үйлчилгээний худалдаалагдсан тасалбарын 1%-ийг хүүхдийн хөгжил, хамгаалалд зарцуулах тухай албан бичгийг соёлын байгууллагуудад хүргүүлсэн. -2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Залуучууд театрын шинэ уран бүтээл “Толбот Цагаан” хүүхдийн мюзикл жүжгийг Соёл, урлагийн газрын албан хаагчдын хүүхдүүдэд үзүүлэв.	95%
6	➢ Хүүхдийн номын ордон нь “Ирээдүйн уншигчдыг хөтөлнө”	- Орхон сумын Соёлын төвөөс “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”-ийг угтан зохион байгуулсан уралдаанд идэвхтэй оролцсон тус сумын 8 дугаар сургуулийн 5 дугаар ангийн 20 хүүхдэд “Зүрхэнд Гэрэлтэнэ” МУСК-ны 20 ширхэг билетийг аймгийн Соёл, урлагийн газраас гардууллаа. Өсвөр насны хүүхдүүдийг хүсэл мөрөөдлийнхөө төлөө зүтгэх, амьдралын зорилготой болгох зам тээврийн осол, гэмтлээс сэргийлэх уриатай энэхүү уран бүтээл 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Залуучууд театрт нээлтээ хийсэн.	95%
7	➢ Залуучууд театр нь “Бид соёлыг түгээж ирээдүйн	- “Кинонд ээлтэй хот” болох зорилтын хүрээнд Дархан Өргөө кино театр нь 450 хүүхдэд кино үзэх эрх олгов. Тус эрхийн бичгийг аймгийн Засаг даргын Тамгын газарт өгөв.	100%

8	<p>соёлтой үзэгчийг бэлтгэнэ”</p> <p>➤ Төв номын сан нь “Оюунлаг хүүхдийн төлөө”</p> <p>➤ Аймгийн Музей нь “Хайрлагдсан хамгаалагддаг” хүүхэд</p>	<p>- Дархан-Уул аймгийн Засаг даргын нэрэмжит ЕБС, техник мэргэжлийн коллежийн оюутан, сурагчдад эх оронч үзлийг төлөвшүүлэх “БИД ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ” төсөлд аймгийн Соёл, урлагийн газар нь хамтран ажиллав. Төслийн хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр “ЭХ ОРОНЧ ҮЗЛИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ” соёлын өдөрлөгийг Залуучууд театрт зохион байгуулсан. 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр “ДӨЛ” цогцолбор тэмцээний “Тусгай байр”-анд шалгарсан ЕБ-ын 9 дүгээр сургуулийн тасагт баяр хүргэж ном, баярын бэлгийг гардууллаа.</p>	95%
9		<p>-Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс аймгийн Соёл, урлагийн “Эцэг эхийн зөвлөл”-өөс газрын пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хандсан нөлөөллийн ажлууд, зөвлөмж бүхий зурагт хуудсыг тогтмол хийж байна. Тайлант хугацаанд шинэ жил, цагаан сар, сурагчдын амралт, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх болон ахуйн ослоос урьдчилан сэргийлэх агуулга бүхий нийт 6 удаагийн зураг хуудасны эх бэлтгэж, иргэдэд олон нийтэд сурталчилсан байна.</p>	90%
Дундаж хувь			96.1%

**ТАЙЛАНГ ГАРГАСАН: СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ДОЛГОРМАА**



Зураг-1. Залуучууд театрын “Толбот Цагаан” хүүхдийн мюзикл жүжгийг газрын албан хаагчдын хүүхдүүдийг үзүүлэв. /2023.05.13/



Зураг-2. “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”-ээр Орхон сумын 8-р сургуулийн 5 дугаар ангийн 20 хүүхдэд “Зүрхэнд гэрэлтэнэ” МУСК-г үзүүлэв. /2023.05.14/



Зураг-3. “Шонхоодой” циркийн 3 хүүхдэд хүнс, ахуйн тусламж үзүүлэв. /2023.05.05/



Зураг-4. Дархан-Уул аймгийн Засаг даргын нэрэмжит “Бид эх орны ирээдүй” төслийн хаалт /2023.05.29/



Зураг-5. 6. “Нэгдүгээрт хүүхэд” уриан дор Соёл, урлагийн газрын пэйж хуудсанд нөлөөллийн ажлыг хийж байна.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР